

Сангийн сайдын 2023 оны .....  
дугаар/дүгээр сарын ..... өдрийн ....  
дугаар/дүгээр тушаалын хавсралт.

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

**ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР  
ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ  
БАРИМТ БИЧИГ**

2023 он

[ЗАХИАЛАГЧИЙН НЭР]

ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ  
БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

*[төсөл, арга хэмжээний батлагдсан нэр бичих]*

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

*[тендер шалгаруулалтын дугаарыг бичих]*

## ОРШИЛ

Захиалагч энэхүү жишиг баримт бичгийн дагуу тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахдаа худалдан авах ажиллагааны өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, хариуцлагатай, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчид үндэслэн тухайн тендер шалгаруулалтыг зохион байгуулах, гэрээний хэрэгжилтид ач холбогдол бүхий шаардлага, шалгуур үзүүлэлтийг тусгах нь зүйтэй.

Үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг нь зааварчилгаа, тендерийн өгөгдлийн хүснэгт, техникийн тодорхойлолт, тендерийн үнэлгээн харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт, тендерийн жишиг маягт, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл гэсэн бүлэг, бүлэг бүр зүйл, заалттай байна.

Зааварчилгаа бүлэг нь захиалагч болон оролцогч, сонирхогч этгээдэд зориулагдсан. Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, оролцогч өөрийн тендер бэлтгэн ирүүлэх үед зааварчилгааны зүйл, заалтыг өөрчилж үл болох ба тендер шалгаруулалт зохион байгуулахад зааварчилгааг мөрдлөг болгоно.

Захиалагч зааварчилгаа бүлэгт заасантай нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтийг боловсруулах бөгөөд оролцогч зааварчилгаа, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрийн тендерийг бэлтгэнэ ирүүлнэ.

Техникийн тодорхойлолтод үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар түүний зориулалт, зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгахаас гадна үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлт, хүний эрүүл мэнд, байгаль орчин, уур амьсгалд нөлөөлөх нөлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх шалгуур үзүүлэлт, үйлчилгээ үзүүлэх явцад баримтлах тусгайлсан шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгаж болно.

Аж ахуй эрхлэгч, сонирхогч этгээд, оролцогч өөрийн тендерийг бэлтгэх, илгээхдээ тендер шалгаруулалтын зааварчилгаа, өгөгдлийн хүснэгттэй сайтар танилцаж, шаардлагатай тохиолдолд захиалагчаас холбогдох журмын тодруулга авах, мөн маягтын агуулгыг өөрчлөхгүйгээр илгээхэд анхаарна уу.

Бид энэхүү жишиг баримт бичгийг боловсруулахдаа худалдан авах ажиллагаа дахь хүний оролцоог бууруулах, тендер шалгаруулалтын зохион байгуулахад хялбар байх, түүний нээлттэй, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх бодлогын шинэчлэлийг тусгахыг зорилго болголоо.

Иймд захиалагчид, оролцогч та бүхнийг худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалт зохион байгуулахад энэхүү жишиг баримт бичиг тус болно гэдэгт бид найдаж байна.

Хэрэв үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийг үндэслэн тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, тендер шалгаруулалт зохион байгуулах, тендерийн үнэлгээ хийхтэй холбоотой санал, хүсэлтийг дараах хаягаар ирүүлнэ үү.

САНГИЙН ЯАМ,  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗАР,  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН ХЭЛТЭС

Холбоо барих:  
Утасны дугаар: 51-267416  
Цахим шуудан: [info@mof.gov.mn](mailto:info@mof.gov.mn)  
Цахим хаяг: [www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn)

ТӨСӨЛ

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ).....	1
1. Тендерийн цар хүрээ.....	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж.....	1
4. Сонирхогч этгээд, оролцогч.....	1
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ.....	2
6. Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүлэг.....	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах.....	2
8. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах.....	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	3
10. Тендерийн хэл шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл.....	3
11. Тендерийн иж бүрдэл.....	3
12. Тендерийн жишиг маягтууд.....	4
13. Хувилбарт санал.....	4
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг.....	5
15. Чадавхын болон туршлагын шаардлага.....	5
16. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт.....	6
17. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт....	6
18. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	6
19. Тендерийн валют.....	7
20. Тендер хүчинтэй байх хугацаа.....	7
21. Тендерийн баталгаа.....	8
22. Тендер баталгаажуулах, илгээх.....	8
23. Тендер хүлээн авах эцсийн хугацаа.....	9
24. Тендерийн талаар тодруулга авах.....	9
25. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	9
26. Тендерийг үнэлэх.....	9
27. Арифметик алдааг залруулах.....	9
28. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт.....	10
29. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	10
30. Тендерийг эрэмбэлэх.....	11
31. Оролцогчийн чадавхыг дахин магадлах.....	11
32. Мэдэгдэл хүргүүлэх.....	11
33. Гүйцэтгэлийн баталгаа.....	12

34. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	12
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	1
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	2
Маягт 1 Тендер илгээх маягт.....	3
Маягт 2 Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл.....	5
Маягт 3 Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл.....	5
Маягт 4 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл.....	6
Маягт 5 Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт.....	7
VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ.....	1
<i>САНАМЖ</i> .....	1
<b>1.1 Нэр томъёоны тайлбар</b> .....	2
<b>1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль</b> .....	3
<b>1.3 Гэрээнд ашиглах хэл</b> .....	3
<b>1.4 Мэдэгдэл</b> .....	3
<b>1.5 Байршил</b> .....	3
<b>1.6 Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ</b> .....	3
<b>1.7 Итгэмжлэгдсэн төлөөлөгч</b> .....	3
<b>1.8 Татвар, хураамж</b> .....	3
<b>1.9 Авилгал болон залилан мэхлэх үйлдэл</b> .....	3
ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ.....	4
ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ.....	5
ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ.....	8

<b>I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)</b>	
<b>А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>	
<b>1. Тендерийн цар хүрээ</b>	<p>1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгт (цаашид “ӨХ” гэх)-д заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээг худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна.</p> <p>1.2. Захиалагч тендер шалгаруулалтын нэр, дугаарыг ӨХ-д заана.</p>
	1.3. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг ӨХ-д заана.
	1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай ӨХ болон зарлалд заана.
<b>2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг</b>	2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг ӨХ-д тусгана.
<b>3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж</b>	<p>3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.</p> <p>3.2. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.</p> <p>3.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.</p>
<b>4. Сонирхогч этгээд, оролцогч</b>	<p>4.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.</p> <p>4.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.</p>

	4.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
	4.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
	4.5. Үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
<b>5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ</b>	5.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
	5.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
	5.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
<b>Б.АГУУЛГА</b>	
<b>6. Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүлэг</b>	6.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэгтэй байна. I Бүлэг.Тендер шалгаруулалтын зааварчилгаа; II Бүлэг.Өгөгдлийн хүснэгт; III Бүлэг.Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага; IV Бүлэг.Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт; V Бүлэг.Тендерийн жишиг маягт; VI Бүлэг.Гэрээний нөхцөл.
	6.2. Аж ахуй эрхлэгч, сонирхогч ТШЗ, ӨХ-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
<b>7. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах</b>	7.1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу ӨХ-д заасан хаягаар хүргүүлнэ.
	7.2. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.



<p><b>8. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах</b></p>	<p>8.1. Тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болвол хуулийн 20.6-д заасныг баримтална.</p>
<p><b>9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт</b></p>	<p>9.1. Захиалагч хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол ӨХ-д заана. 9.2. Уулзалтад аж ахуй эрхлэгч, сонирхогч этгээд, тэдгээрийн төлөөллийг оролцуулна.</p>
	<p>9.3. Уулзалтад оролцоогүй нь тендер шалгаруулалтад аж ахуй эрхлэгчийн оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.</p>
<p><b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b></p>	
<p><b>10. Тендерийн хэл шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл</b></p>	<p>10.1. Тендерийн шалгаруулалтын хэл ТШЗ 10.3-т зааснаас бусад тохиолдолд Монгол хэл байна. 10.2. Оролцогч тендерт ТШЗ 10.1-д зааснаас өөр хэлээр баримт бичиг ирүүлэх шаардлагатай бол түүний орчуулгыг хавсаргана.</p>
	<p>10.3. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын тендерийн баримт бичгийн хэлийг Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ӨХ-д өөрөөр зааж болно.</p>
	<p>10.4. Монгол хэлээр боловсруулсан ТШББ болон гадаад хэлээр боловсруулсан ТШББ хоорондоо зөрвөл ТШЗ-ны 9.1-д заасан хэл дээрх ТШББ-ийг баримтална.</p>
	<p>10.5. Захиалагч ТШЗ-ны 9.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.</p>
<p><b>11. Тендерийн иж бүрдэл</b></p>	<p>11.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.</p>
	<p>11.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:</p>
	<p>11.2.1. ТШЗ-ны 12 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;</p>

	11.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
	11.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 13 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
	11.2.4. оролцогч ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
	11.2.5. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
	11.2.6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь;
	11.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 16, ТШЗ 17, ТШЗ 18 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
	11.2.8. ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан үнийн задаргаа;
	11.2.9. ТШЗ-ны 19.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
	11.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.
	11.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
	11.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
<b>12.Тендерийн жишиг маягтууд</b>	12.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
<b>13.Хувилбарт санал</b>	13.1. ӨХ-д тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
	14.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.

<p><b>14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг</b></p>	<p>14.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.</p>
	<p>14.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:</p>
	<p>14.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;</p>
	<p>14.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;</p>
	<p>14.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.</p>
	<p>14.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.</p>
<p><b>15. Чадавхын болон туршлагын шаардлага</b></p>	<p>15.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг ӨХ-д заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.</p>
	<p>15.2. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол ӨХ-д заана. Тухайн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.</p>

	15.3. Түншлэл нь ТШЗ-ны 16.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ӨХ-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
	15.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
<b>16. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт</b>	16.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож ӨХ-д заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг ӨХ-д заана.
	16.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
	16.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгуулагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
<b>17. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт</b>	17.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож ӨХ-д заана.
<b>18. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт</b>	18.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
	18.2. Үнийн задаргаанд бүрийн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.

	18.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 12 дугаар зүйлд заасан тендер илгээх маягтад заана.
	18.4. ТШЗ 19.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
	18.5. Хууль болон ӨХ-д өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. ӨХ-д үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
	18.6. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
	18.7. ТШЗ-ны 19.2-т заасан үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.
	18.8. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
<b>19. Тендерийн валют</b>	19.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
<b>20. Тендер хүчинтэй байх хугацаа</b>	20.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.

	20.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 22 дугаар зүйлд заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
	20.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
<b>21. Тендерийн баталгаа</b>	21.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг ӨХ-д заана.
	21.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 22.1-д зааснаар ирүүлнэ.
	21.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
<b>22. Тендер баталгаажуулах, илгээх</b>	22.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 22 дугаар зүйлд зааснаар илгээнэ.
	22.1.1.
	22.2. ТШЗ-ны 23.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.
	22.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 23.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
	22.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

	22.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 23.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг ӨХ-д заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
<b>23.Тендер хүлээн авах эцсийн хугацаа</b>	23.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг ӨХ-д заана. Огноо, цагийг цахим системийн цагаар тооцно.
	23.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр ӨХ-д заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.
<b>Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ</b>	
<b>24.Тендерийн талаар тодруулга авах</b>	24.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
<b>25.Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх</b>	25.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
<b>26.Тендерийг үнэлэх</b>	26.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
	26.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтын үнэлгээг IV бүлэгт заасан чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуураар үнэлж харьцуулна.
<b>27.Арифметик алдааг залруулах</b>	27.1. Тендерийн үнийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
	27.1.1. нэр төрлийн мөр дэх нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэгж үнийг үндэслэн түүний мөр дэх нийт үнийг залруулна. Харин нэгж үнийн аравтын орны таслалыг илэрхий алдсан гэж үзвэл тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна;
	27.1.2. мөр дэх үнийн нийлбэр эсхүл ялгаварт алдаа байвал мөр дэх үнийг үндэслэн нийт үнийг залруулна;

	27.1.3. тоо болон үгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоон дүнг залруулна. Харин үгээр илэрхийлсэн дүн нь арифметик алдаанаас шалтгаалсан бол ТШЗ-ны 33.1.1, 33.1.2-т нийцүүлэн тоогоор илэрхийлсэн дүнг баримтална.
	27.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
<b>28. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт</b>	28.1. ӨХ-д заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
<b>29. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох</b>	29.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:
	29.1.1. ТШЗ-ны 19 дүгээр зүйлд зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;
	29.1.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
	29.1.3. ТШЗ-ны 19.3-т заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;
	29.1.4. ТШЗ-ны 33.1.1, 33.1.2, 33.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 29 дүгээр зүйлд зааснаар нэг валютад хөрвүүлэх;
	29.1.5. ТШЗ-ны 32.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
	29.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:
	29.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг ТШЗ-ны 33.1-д заасны дагуу сонгох;



	<p>29.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 35.2-т зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;</p>
	<p>29.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.</p>
	<p>29.3. ТШЗ-ны 13.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.</p>
	<p>29.4. ТШЗ-ны 33.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.</p>
<b>30. Тендерийг эрэмбэлэх</b>	<p>30.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.</p>
<b>31. Оролцогчийн чадавхыг дахин магадлах</b>	<p>31.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.</p>
	<p>31.2. ТШЗ-ны 33.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.</p>
	<p>31.3. ТШЗ-ны 33.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.</p>
<b>Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>32. Мэдэгдэл хүргүүлэх</b>	<p>32.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.</p>

<b>33. Гүйцэтгэлийн баталгаа</b>	33.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
	33.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын дагуу гаргана.
<b>34. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах</b>	34.1. Захиалагч ТШЗ-ны 7.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
	34.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 36.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

<b>ТШЗ-ны холбогдо х заалт</b>	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагч: <i>[захиалагчийн нэрийг бүрэн, товчлохгүйгээр бичих]</i>
<b>ТШЗ 1.2</b>	Тендер шалгаруулалтын нэр: <i>[төсөл, арга хэмжээний батлагдсан нэр, дугаарыг бүтэн бичих]</i>  Тендерийн урилгын дугаар: <i>[цахим системд заасан тендер шалгаруулалтын урилгын дугаарыг бичих]</i>
<b>ТШЗ 1.3</b>	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:  <i>Багц № 1: багцын нэр,</i>  <i>Багц № 2: багцын нэр...гэх мэт.</i>
<b>ТШЗ 1.4</b>	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <i>[“Тийм” эсхүл “Үгүй” гэж бичих].</i>
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>[эрх бүхий этгээдээс баталсан санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө, орон нутгийн төсвийн хөрөнгө, тухайн байгууллагын өөрийн хөрөнгө, эсхүл зээлийн хөрөнгө гэх зэргээр тодорхой, товчлохгүй бичих]</i>  Нийт төсөвт өртөг: <i>[мөнгөн дүн бичих]</i>  <i>[Хэрэв багцад хуваасан бол багц тус бүрийн төсөвт өртгийг бичих:</i>  <i>Багц №...: _____</i>  <i>Багц №...: _____]</i>
<b>Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 8.1</b>	Тендерийн баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:  Хүлээн авагчийн нэр: <i>[хариуцсан ажилтны албан тушаал, нэрийг бичих]</i>  Хаяг: <i>[хүсэлт хүлээн авах хаягийг бичих]</i>  Утасны дугаар: <i>[албан байгууллагын утасны дугаарыг бичих]</i>

	Цахим шуудангийн хаяг: <b>[албан байгууллагын цахим шуудангийн хаягийг бичих]</b>
<b>ТШЗ 9.1</b>	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>["Тийм" эсхүл "Үгүй" гэж бич. Хэрэв "Тийм" бол уулзалт болох газар, огноо, цагийг бичих]</b>
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 10.2</b>	Тендер шалгаруулалтын хэл: [Монгол хэл] <b>["Монгол хэл" эсхүл аль нэг гадаад хэлийг сонгож бичих]</b>
<b>ТШЗ 13.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>["Зөвшөөрнө" эсхүл "Зөвшөөрөхгүй" гэж бичих].</b>
<b>ТШЗ 14.1</b>	Оролцогч тендер шалгаруулалтын зааварчилгааны 14.1-д заасны дагуу ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичгүүдийг ирүүлнэ.
<b>ТШЗ 15.1</b>	<p>Үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн мэдээлэл: <b>["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардах бол уг үйлчилгээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаар шаардах мэдээллийг тодорхой бичих]</b></p> <p>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: <b>["Шаардлагатай" эсхүл "Шаардлагагүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих.]</b></p> <p>Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: <b>["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардах бол тухайн үйлчилгээ үзүүлэхэд зайлшгүй шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд тавигдах шаардлагыг тодорхой заах]</b></p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: <b>["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих. Зөвхөн ТШЗ-ны 18.6.1-18.6.7-д зааснаас бусад мэдэгдэл, баримт бичгийг бичнэ. ТШЗ-ны 18.6-д заасан оролцогчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг нэмэгдүүлэхгүй]</b></p>
<b>ТШЗ 16.1</b>	<p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p><b>[Санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтооход үйлчилгээ үзүүлэх зайлшгүй шаардлагатай шалгуур үзүүлэлтийг тусгах ба хувь хэмжээг үндэслэлгүй]</b></p>

	<p><b>тогтоохгүй байхыг анхаарна уу. Тавигдах шаардлагын жишээ нь дараах байж болох боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:</b></p> <p><b>Борлуулалтын орлогын хэмжээ: ТШЗ-ны 18.3-т заасан хугацаанд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн [тоо бичих] хувиас багагүй байх.]</b></p> <p>Оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: <b>[Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтоохдоо үйлчилгээний онцлог, тоо хэмжээг харгалзан зайлшгүй шаардлагыг тусгана. Тухайлбал дараах шаардлагууд байж болох ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:</b></p> <p><b>Ижил төстэй гэрээний туршлага: [Хэрэв шаардлагатай бол гэрээний мэдээлэл ирүүлэх жилийн тоо, нотлох баримт бичгийг тодорхой заах. [Жишээ: Уг хугацаанд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн [●] хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээ доод тал нь [●] удаа. Захиалагч ижил төстэй үйлчилгээг тухайлан зааж болно.]</b></p> <p><b>ӨХ-д шаардсан бол тендерт оролцогчоролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 6-ын дагуу ирүүлнэ. ТШЗ-ны 16.1-д заасан чадавхыг магадлахад энэ мэдээллийг ашиглана.</b></p> <p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>[“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардах бол зөвшөөрөл олгодог байгууллага, тусгай зөвшөөрлийн нэрийг тодорхой бичих]</b></p>
<p><b>ТШЗ 17.1</b></p>	<p>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: <b>[Захиалагч үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацааг тодорхой заана.]</b></p>
<p><b>ТШЗ 17.1</b></p>	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: <b>[“Тийм” эсхүл “Үгүй” гэж бичих.]</b></p> <p><b>[“Тийм” гэж хариулсан бол санхүүгийн чадавхтай холбоотойгоор хуулийн 16.2, 16.4-т заасан дараах баримт бичгээс сонгож шаардаж болох ба бусад баримт бичиг шаардахыг хуулиар зөвшөөрөөгүй болохыг анхаарна уу. Сүүлийн гурав хүртэл жилээс аль аль оны мэдээллийг шаардахыг тодорхой заана.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- харилцагч банкны мэдэгдэл;</li> <li>- Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх</li> </ul>

	<p><b>талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан;</li> <li>- сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл.</li> </ul> <p><b>-санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт.]</b></p>
<b>ТШЗ 18.1</b>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: [<b>“Тийм” эсхүл “Үгүй” гэж бичих.</b>]</p> <ul style="list-style-type: none"> <li>- гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл;</li> <li>- оролцогчийн туршлагыг харуулах ӨХ-д заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 2, Маягт 4-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл;</li> <li>- Үйлчилгээ үзүүлэхэд ашиглахаар ТӨХ болон техникийн тодорхойлолтод заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, тэдгээрийг цаг хугацаанд нь (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх гэх мэт) бэлэн байлгах санал;</li> <li>- техникийн чадавх болон туршлагын талаар ТШЗ-ны 16.1-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлох ТӨХ-д заасан бусад баримт.</li> </ul> <p>Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: [<b>“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэж бичих</b>]</p>
<b>ТШЗ 19.5.</b>	<p>Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: [<b>“Тохируулж болно” эсхүл “Тохируулахгүй тогтмол байна” гэж бичих. Хэрэв гэрээний үнийг тохируулах бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг захиалагч тендер зарлахаас өмнө урьдчилан тогтоож, аргачлалыг гэрээнд тусгана.</b>]</p>
<b>ТШЗ 19.6</b>	<p>Үйлчилгээ үзүүлэх байршил:</p>
<b>ТШЗ 20.1</b>	<p>Оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа: 30-аас багагүй өдөр байх</p>
<b>ТШЗ 21.1</b>	<p>Тендерийн баталгааны дүн: [<b>Тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 0.5 хувиар тооцож заах ба багцтай бол багц тус бүрээр заана:</b></p>

	<p><b>Багц №1: [●] төгрөг;</b></p> <p><b>Багц №2: [●] төгрөг.]</b></p>
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
<b>ТШЗ 22.5.</b>	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p><b>[Жишээ нь:</b></p> <p><b>1. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл;</b></p> <p><b>2. Санал болгосон бараг нийлүүлэх боломжтой болохыг нотлох баримт гэх мэт баримт бичгийг жагсаан бичих]</b></p>
<b>ТШЗ 23.1.</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>[он, сар, өдрийг бичих]</b></p> <p>Цаг: <b>[цаг, минутыг тодорхой бичих]</b></p>
<b>ТШЗ 23.2.</b>	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <b>[он, сар, өдрийг бичих. Жишээ нь: 20.. оны .. дугаар сарын ..-ны өдөр]</b></p> <p>Цаг: <b>[цаг, минутыг тодорхой бичих. Жишээ нь: .. цаг .. минут г.м]</b></p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <b>[аймаг/хот, сум/дүүрэг, гудамжны нэр, байшингийн дугаар, давхар, өрөөний дугаар]</b></p>
<b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>	
<b>ТШЗ 29.1</b>	<p>Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: <b>[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих]</b></p> <p><b>Хэрэв “Ашиглах” бол IV бүлгийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтээс аль тохирохыг тусгана]</b></p>
<b>Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>ТШЗ 34.1</b>	<p>Гэрээ байгуулах эрх авсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <b>[“Тийм” эсхүл “Үгүй” гэж бичих]</b></p> <p><b>[Хэрэв “Тийм” гэж хариулсан бол доорх өгүүлбэрийг бичих:</b></p> <p><b>ТШЗ-ны 8.5-т заасан гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.]</b></p> <p><b>[Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн</b></p>

	<i>үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.]</i>
--	--

<b>Ё. БУСАД</b>
-----------------



III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[

*АЖЛЫН ДААЛГАВАР*

*[ажлын даалгаарыг хавсаргана уу.]*

#### IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.*

*Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна ТШЗ-ны 35.1.6-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.*

*Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.*

**[Захиалагч байгууллагын нэр]-д**

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэх, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт **[“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]**. **[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]**.
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.<sup>1</sup>
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

<sup>1</sup> Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,  
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,  
албан тушаал, гарын үсэг,  
байгууллагын тамга, тэмдэг]:***

***Хаяг:***



**[Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол өөрийн нэрийн өмнөөс захиалагчтай харилцах, мэдэгдэл хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгуулагдсан эрх бүхий этгээдийг заана уу.]**

*[Баталгаа гаргагчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]*

Маягт 2

**Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл**

<b>Гэрээний нэр</b>	<b>Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас</b>	<b>Төсөвт өртөг</b>	<b>Хугацаа /эхэлсэн, дууссан/</b>

Маягт 3

**Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

<b>Гэрээний нэр</b>	<b>Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас</b>	<b>Төсөвт өртөг</b>	<b>Гэрээ эхэлсэн хугацаа</b>	<b>Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр</b>	<b>Дуусах хугацаа</b>

**Маягт 4 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч



Маягт 5

**Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	<b>Нууцалсан баримт бичиг, мэдээлэл</b>	<b>Нууцалсан хууль зүйн үндэслэл</b>
1.		
2.		
3.		
4.		
5.		

## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### САНАМЖ

*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын үр дүнд гэрээ байгуулах эрх олгосон оролцогчтой гэрээ байгуулахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.*

*Гэрээ нөхцөл нь гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх) гэх хэсэгтэй ба тус хоёр нөхцөлд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.*

*ГТН-ийг тухайн үйлчилгээ худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:*

- *ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгаахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн үйлчилгээ худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;*
- *Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;*
- *Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;*
- *Ажлын даалгавар, холбогдох мэдээллийг гэрээнд хавсаргах;*
- *ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;*
- *Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ боловсруулна.*

## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### 1.1 Нэр томъёоны тайлбар

Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Гэрээнд хэрэглэх хууль” гэж Гэрээний тусгай нөхцөл ГТН-д заасан Монгол улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ.
- (б) “Зөвлөх” гэж захиалагчтай байгуулсан энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж байгаа аливаа хувийн болон төрийн хуулийн этгээдийг хэлнэ.
- (в) “Гэрээ” гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт болон түүний 1 дүгээр заалтад дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ.
- (г) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- (е) “Гэрээ хүчин төгөлдөр болох огноо” гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ.
- (д) “Гэрээний үнэ” гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Зөвлөхөд төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ.
- (е) “ГЕН” гэж Гэрээний ерөнхий нөхцлийг хэлнэ.
- (ё) “Гишүүн” гэж түншлэл/консорциум/холбоог бүрдүүлж байгаа аль нэгэн хуулийн этгээдийг “Гишүүд” гэж эдгээр хуулийн этгээдийг хамтад нь хэлнэ.
- (ж) “Гэрээний тал гэж” Захиалагч эсхүл Зөвлөхийн аль нэгийг, харин “Талууд” гэж хоёуланг нь хэлнэ.
- (з) “Нөхөн төлөх зардал” гэж зөвлөхийн ажлын хөлснөөс бусад үйл ажилгаатай холбоотой бүх зардлуудыг хэлнэ.
- (л) “ГТН” гэж гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцлийг хэлнэ.
- (м) “Үйлчилгээ” гэж Хавсралт №1-т тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Зөвлөхийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ.
- (о) “Туслан гүйцэтгэгч” гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Зөвлөхтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
- (ө) “Ажиллах хүчин ” гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Зөвлөхийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.

- 1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль** Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3 Гэрээнд ашиглах хэл** Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
- 1.4 Мэдэгдэл** Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстой. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстой.
- 1.5 Байршил** Үйлчилгээг, гэрээний хавсралт №1-т заасан нутаг дэвсгэрт, хэрэв тодорхой төсөл арга хэмжээний байрлалыг заагаагүй тохиолдолд захиалагчийн харъяа улс эсхүл түүний тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ёстой.
- 1.6 Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ** Зөвлөх нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд, эдгээр гишүүд гэрээний дагуу захиалагчтай үүсэх харилцаанд бүх гишүүний нэрийн өмнөөс оролцох, эрх хэрэгжүүлэх болон үүрэг хүлээх, зааварчилгаа болон төлбөр хүлээн авахад тэднийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг томилно.
- 1.7 Итгэмжлэгдсэн төлөөлөгч** Гэрээний дагуу захиалагч эсхүл зөвлөхийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ.
- 1.8 Татвар, хураамж** Зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой.
- 1.9 Авилгал болон залилан мэхлэх үйлдэл** Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч зөвлөх бүр худалдан авах ажиллагаанд оролцох, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.
- Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон зөвлөх нь Авилгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

(Хаалтанд байгаа зүйлийг { } сонгон хэрэглэнэ; эцэслэн боловсруулалт хийхэд тэмдэглэлийг хасна)

<b>ГЕН-ийн зүйлийн дугаар</b>	Гэрээний ерөнхий нөхцлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчлөнө.
<b>{1.1(а)}</b>	Гэрээнд хэрэглэх хууль нь { Монгол улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актууд}
1.3	Гэрээний баримт бичгүүд нь <b>[хэл]</b> хэл дээр байна.
1.4	<p><b>Захиалагчийн хаяг:</b></p> <p><b>Захиалагч:</b>  <b>Харилцах хүн:</b>  <b>Утас:</b>  <b>Факс:</b></p> <p><b>Захиалагч:</b></p> <p><b>Харилцах хүн:</b></p> <p><b>Утас:</b></p> <p><b>Факс:</b></p> <p><b>И-мэйл:</b></p>
{1.6}	<p>{Төлөөлөх эрх бүхий гишүүн <b>[гишүүний нэрийг оруул]</b>}</p> <p><u>Тэмдэглэл:</u> <b>Зөвлөх нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд ГТН-ийн 1.5-д байгаа хаягийг энд оруулна. Зөвлөх дангаар оролцож байгаа бол ГТН-ийн энэ зүйлийг бүхэлд нь хасна.</b></p>
1.7	<p><b>Итгэмжлэгдсэн төлөөлөгчид:</b></p> <p><b>Захиалагчийн:</b></p> <p><b>Зөвлөхийн:</b></p>
1.8	<p>Татвар <b>[Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэхэд төлөх татвар, хураамжийн талаарх мэдээллийг бичнэ]:</b></p> <hr/> <p><u>Тэмдэглэл:</u> <b>Гэрээнд хэрэглэх хуулийн дагуу зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажилтнуудын төлбөл зохих татвар хураамж болон эсхүл захиалагч нөхөн олгох буюу эсхүл тодорхой татвар, хураамж төлбөрөөс чөлөөлөгдөх ёстой зэргийг энд оруулна.</b></p>
{2.1}	<p>{Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр: <b>[огноог оруул]</b>}</p> <p><u>Тэмдэглэл:</u> <b>Гэрээ хүчин төгөлдөр болох огноо нь санхүүжүүлэгч байгууллагын зөвшөөрөл зэрэг нэмэлт нөхцөлөөс хамааралтай байж болно. Талууд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болох бол ГТН-ийн энэ хэсгийг бүхэлд нь хасна.</b></p>

2.2	<b>Тогтоосон хугацаа: [хугацааг оруул, жишээлбэл: нэг сар г.м].</b>
2.3	<b>Тогтоосон хугацаа: [хугацааг оруул, жишээлбэл: 12 сар г.м].</b>
3.4	<p>Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ нь:</p> <p>(а) Машин механизм, тоног төхөөрөмжийн алдагдал, эсхүл гэмтлийн даатгалд зөвлөхийн доод хэмжээ нь <i>[мөнгөн дүн]</i> байна.</p> <p>(б) Гуравдагч этгээдийн хариуцлагын даатгалд зөвлөхийн төлөх хэмжээ нь <i>[мөнгөн дүн]</i> байна.</p> <p>(в) Мэргэжлийн хариуцлагын даатгалд зөвлөхийн төлөх хэмжээ нь <i>[мөнгөн дүн]</i> байна.</p> <p>(г) Гэнэтийн ослын, амь нас, эрүүл мэндийн хувьд гэрээнд хэрэглэх хуулийн дагуу ажил олгогчийн хүлээх хариуцлагын даатгалд зөвлөхийн төлөх хэмжээ нь <i>[мөнгөн дүн]</i> байна.</p> <p><b>Тэмдэглэл: Энд хэрэглэх шаардлагтай гэж үзсэн даатгалын заалтыг нэмэх эсхүл хэглэхгүй заалтыг хасна.</b></p>
{3.5 (в)}	{Бусад үйл ажиллагаа : <b>[захиалагчийн шаардлагтай гэж үзсэн үйл ажиллагааг оруул].</b> }
{5.1}	<b>Тэмдэглэл: ГЕН-ийн 5.1 зүйлд заасны дагуу захиалагчийн зүгээс үзүүлэх тусламж дэмжлэг, зөвшөөрөлийн жагсаалтыг оруул. Ийм зүйл байхгүй бол ГТН-ийн энэ хэсгийг бүхэлд нь хасна.</b>
6.2(а)	Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн дээд хэмжээ: <b>[мөнгөн тэмдэгт бүрээр хэмжээг тоо болон үсгээр оруул]</b>
6.2(б)	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: <b>[хэмжээг тоо болон үсгээр оруул]</b>
6.4	<p>Төлбөр хийх данснууд:</p> <p>Гадаад мөнгөн тэмдэгийн хувьд: <b>[дансны нэр, дугаарыг оруул].</b></p> <p>Төгрөгийн хувьд: <b>[дансны нэр, дугаарыг оруул].</b></p> <p><b>Төлбөрийг дараахь хуваарийн дагуу төлнө.</b></p> <p><b>Тэмдэглэл: (а) дор дурдсан төлбөрийн хуваарь нь зөвхөн дүн шинжилгээ хийх, жишээ болох зорилготой; (б) гадаад мөнгөн тэмдэгт болон төгрөгөөр хийх хуваарь хаирлцан адилгүй бол салангид хуваарь гаргаж мөрдөнө</b></p> <p>(а) Гэрээний үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх дүнг, урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлсэн тохиолдолд үйлчилгээг эхлүүлэх өдөр төлнө.</p> <p>(б) Гэрээний үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх дүнг эхлэлтийн тайлан ирүүлсний дараа төлнө.</p> <p>(в) Гэрээний үнийн дүнгийн 25 хувьтай тэнцэх дүнг дунд хугацааны тайлан ирүүлсний дараа төлнө.</p> <p>(г) Гэрээний үнийн дүнгийн 25 хувьтай тэнцэх дүнг эцсийн тайлангийн төслийг ирүүлсний дараа төлнө.</p> <p>(д) Гэрээний үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх дүнг эцсийн тайланг хүлээн зөвшөөрсний дараа төлнө.</p>

	<p>(e) Гэрээний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх дүнг төлснөөр гэрээний гүйцэтгэлийн баталгааг цуцлаж болно.</p> <p><i>Тэмдэглэл: Энэхүү зүйлийг гэрээ бүрийн шинж чанарт тохируулан боловсруулах ёстой.</i></p>
6.5	<b>Хүүгийн хувь хэмжээ: [хүүгийн хэмжээг оруул].</b>
8.2	<p>Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүх, эсхүл дотоодын болон гадаадын арбитрийн аль нэгэн байгууллагыг маргааныг шийдвэрлүүлэхээр сонгоно. Жишээлбэл, Гадаадын зөвлөхтэй гэрээ байгуулж байгаа тохиолдолд 12 дугаар зүйлийг “Энэ гэрээнээс үүдсэн болон энэ гэрээтэй холбогдсон, эсхүл түүнийг зөрчсөн, түүнийг дуусгавар болгосон юм уу хүчингүй болсонтой холбогдсон аливаа маргаан, зөрчилдөөн, нэхэмжлэхийг хүчин төгөлдөр үйлчилж буй UNCITRAL-ын арбитрын журмын дагуу шийдвэрлэнэ.” гэсэн заалтаар сольж болно.</p>



## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

**[Тендер шалгаруулалтын нэрийг бичих]** гэрээ.  
Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

.....  
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[үйлчилгээ үзүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “гүйцэтгэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Үйлчилгээ” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу үзүүлэх Үйлчилгээний үнэ **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Гүйцэтгэгчийн тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 3.6. Ажлын даалгавар;
  - 3.7. Үйлчилгээ үзүүлэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

- 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын \_\_\_\_\_ үсэг]